



**МОНГОЛЫН
БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН
НЭГДСЭН ХОЛБОО**

МБАНХ

Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу
22-ар байр 22а оффис,

Утас: 98113747

E-mail: nfpug.ngo@gmail.com

Web: www.greenmongolia.mn

**БЭЛЧЭЭР АШИГЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
ХАНГАХ ТАЛААР МАЛЧДАД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ
/ГАРЫН АВЛАГА/**



Бодлого судлалын төв

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж 4

Интер оффис, 2-р давхар, Улаанбаатар 14200

Утас: 77119027

Факс: 70119419, e-mail: cpr@cpr.mn

Web: www.cpr.mn

2018 оны 10-р сар

Агуулга

1. Бэлчээр гэж юу вэ	1
2. Бэлчээрийн менежмент гэж юу вэ?	2
3. Бэлчээрийг нийтээр дундаа ашиглахын сөрөг үр дагавар юу вэ?	2
4. Яагаад бэлчээрийг гэрээгээр ашиглах шаардлагатай вэ?	3
5. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах явцад ямар бэрхшээл гарч байна вэ?	4
6. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах явцад гарч байгаа бэрхшээлийг даван туулах нь	
6.1 Гэрээт бэлчээрт гаднаас нүүдэллэн орж ирэх	4
6.2 Гэрээгээр хүлээсэн улирлын нүүдэл хийх хугацааг зөрчих	8
6.3 Отор нэрээр удаан хугацаагаар зорчих	9
6.4 Гэрээнд заагаагүй бэлчээрийн бус зориулалтаар ашиглах	11

1. Бэлчээр гэж юу вэ?

Бэлчээр бол зөвхөн ургамлын бүрхэвч биш. Малын тооны өсөлт, ашиг шимд шууд болон шууд бусаар нөлөөлөгч газрын хотгор гүдгэр, уур амьсгал, ус, хөрс, ургамлын бүрхэвч, зэрэг байгалийн иж бүрдлүүдийн нийлбэр цогцос юм. Энэ утгаараа “нутаг” хэмээх уламжлалт ойлголттой дүйнэ. Малчид сайхан нутаг хэмээн ярихдаа, өвс, ургамал тэгш, өвөлдөө салхи, цаснаас нөмөртэй, дулаан, дундаа сэвэлзүүр салхитай халуун биш гэх мэт байгалийн иж бүрдлүүдийг цогцоор нь авч үзэж, бэлчээрээ шинждэг байна.

2. Бэлчээрийн менежмент гэж юу вэ?

Бэлчээрийн менежмент нь бэлчээр ашиглалт, хамгаалалт нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих цогцолбор арга хэмжээг хамардаг нутгийн захиргаа, малчдын хамтын ажиллагаа юм. Зорилго нь:

- Эдийн засгийн өсөлтийг түргэтгэх (1 га-д ноогдох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ашиг шим болон бэлчээрийн даац гэсэн 2 арга)
- Нийгмийн тэгш ёсыг хангах (малчин бүр өөрийн 4 улирлын бэлчээр, өвөлжөө, хаваржаа, уст цэг, хужир, отрын нөөц нутагтай байх)
- Байгаль орчныг хамгаалах (бэлчээрийн даац хэтрэх, тахлагдахаас хамгаалах гм) гэсэн тогтвортой хөгжлийн үндсэн 3 зорилгыг хангахад чиглэнэ.

3. Бэлчээрийг нийтээр дундаа ашиглахын сөрөг үр дагавар юу вэ?

Үнэ төлбөргүй ашигладаг, хэмжээ хязгааргүй мэт санагдах төрийн өмчийн бэлчээрийн шүүсийг шавхан малынхаа тоог өсгөн ашиг орлогоо нэмэгдүүлэх гэж малчид зүтгэх нь түгээмэл байна. 2017 оны эцэст Монгол улс 66.2 сая мал тоолуулж, түүхэн дээд амжилт тогтоов. “Дэлхий дэлэгнэнэ”, “Хаяа багтвал бууж, хамар багтвал иднэ” гэдэг зарчмаар үнэгүй бэлчээрт малчин, мал бүхий иргэд, бөх, бөө, уяач... гээд бүгд л хошууран дайрч малаа өсгөсний нөгөө талд бэлчээрийн даац хэтрэн цөлжих боллоо. 2014 онд улсын мэргэжлийн байгууллагуудын хийсэн үнэлгээгээр Монгол орны 110 сая га бэлчээрийн 65% доройтолд өртөж, 7% буюу бүхэл бүтэн аймагтай тэнцэх бэлчээр дахин сэргэхгүй болтлоо доройтсон байна. Үндэсний хэмжээнд 2014 оны суурь мэдээлэлтэй харьцуулахад 2016 онд доройтсон бэлчээрийн хувь хэмжээ 65%-иас 57% болж буурсан ч хүчтэй доройтож, цөлжих аюулд хүрсэн бэлчээр нутгийн хэмжээ нэмэгдсэн. Доройтлын зэрэглэлийн нарийвчилсан дүнгээс үзэхэд 2016 оны байдлаар нийт бэлчээрийн 57 % унаган төлөв байдлаас өөрчлөгдөж доройтсоноос 13.5% бага зэрэг, 21.1% дунд зэрэг, 12.8% хүчтэй, 10.3% бүрмөсөн цөлжих эрсдэлд орсон байна. Малаа өсгөөд малчид, МАА-н салбар хожив уу гэвэл үгүй. Малыг дүүрэн идэштэй байлгаж гэвэл хуурай жинд шилжүүлснээр нэг хонин толгойд жилдээ 560 кг бэлчээрийн тэжээл хэрэгтэй. Бэлчээрийн 5 жилийн улсын дундаж ургац 240 кг байна. Ингээд тооцвол 1 малын дүүрэн идэштэй байх хэмжээний бэлчээрийг 2.3 мал хувааж идэж, мал идвэл зохих хэмжээнийхээ 43.4% л идэж, 56.6%-р дутуу хооллож байгаа юм. “Тарган мал тал бүрийн ашигтай” гэж манай малчид ярьдаг шиг мал эмнэлэг, мал зүйн шинжлэх ухаанд малыг эрүүл байлгаж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх суурь нөхцөл бол бүтэн хооллолт гэж үздэг. Энэ байдал алдагдсанаас мал давжааран ашиг шим нь буурч, эрсдэлд амархан өртдөг, өвчлөмтгий болж, чанар нь муудан зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангаж, экспортод гарч

чаддаггүйгээс үнэ цэнэ нь нэмэгдэхгүй харин ч буурч байна. 2005 онд хийсэн эрдэмтдийн судалгаагаар бэлчээрийн доройтлоос шалтгаалан хонины амьдын жин 48-с 44 кг, ямааных 35-с 33 кг болж, хонины ноос, ямааны ноолуурын гарц 2-8%-р буурсан гэсэн дүн гарчээ. Зөвхөн эдгээр гуравхан үзүүлэлтээр тооцоход малын ашиг шим буурснаас малчин өрхийн орлогын алдагдал жил бүр 2.6 сая төгрөг, улсын хэмжээнд 368 тэрбум төгрөг болж байна. **Зураг 1** дээр малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэхийн ач холбогдол, даац хэтрүүлэхийн сөрөг үр дагаврыг Монгол улсын жишээн дээр харуулав. Бэлчээрийн оновчтой даацыг барьж байгаа үед малчны хөрөнгө, орлого болно бэлчээрийн чанар хамгийн өндөр түвшинд, харин бэлчээрийн даац хэтрэхийн хирээр эдгээр үзүүлэлт буурдаг болох нь зураг дээр тодорхой харагдаж байна.



2014 оноос хойш малын тоо 27%-р өссөн боловч малын үнэ цэнэ 37%-р унаж дүнгээрээ малчдын үндсэн хөрөнгө - 10% алдагдал хүлээгээд байна!!!

Зураг 1 Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэхийн ач холбогдол

Ийнхүү жалгын нэг тарж, малаа өсгөх гэж хоёр зудын хооронд гадаа гандаж, хөдөө хөхрөөд үр дүнд нь хожсон зүйлгүй, харин ч бэлчээрээ талхалж, дээр нь отрын бэлчээрээ үгүй хийснээс дараагийн ган, зудаар бүр ч илүү хохирдог, малчдын хөрөнгө орлого нь буурдаг чөтгөрийн тойрогт эргэлдээд байдгийн учир шалтгаан нь бэлчээрийг ямар нэг хариуцлага хүлээлгүй нийтээр нэрийн дор бие биетэйгээ уралдан цөлмөж ашигладаг тогтолцоонд байна.

4. Яагаад бэлчээрийг гэрээгээр ашиглах шаардлагатай вэ?

Газартаа өөриймсөг хандаж, чанарт нь анхаардаг хөшүүрэг 3 нөхцөлөөс бүрддэг байна. Үүнд:

- Газрыг тордож сайжруулсныхаа ашгийг өөрөө л хүртдэг байх /ашгийг нь бусад хүн хүртээд байвал хэзээ ч тордож сайжруулахгүй/
- Чанарыг нь муутгасан бол хариуцлага хүлээлгэдэг тогтолцоо тодорхой
- Аль болох урт хугацаатай, өв залгамжлуулах эрхтэй

Хувийн өмч, удаан хугацааны гэрээгээр ашиглуулах аль аль нь дээрх шаардлагыг хангадаг. Улирлын бэлчээр сэлгэх, ган, зуд гээд байнга нүүдэг, үүнд төрийн зохицуулалт шаардлагатай учраас өмчлөхийг Үндсэн хуулиар хориглосон. Иймд Монгол орны нөхцөлд бэлчээрт өөриймсөг хандаж, зохистой ашиглах сэтгэлгээг төлөвшүүлэх үндсэн арга нь гэрээгээр ашиглуулах явдал болж байна.

Бэлчээрийг гэрээгээр ашиглуулахын үндсэн зорилго нь өнөөгийн эмх замбараагүй ашиглалтыг халж, бэлчээрийг улирлаар хуваарьтай ашиглаж, ган, зудын үед орох нөөц нутагтай байсан шилдэг уламжлалыг сэргээн тогтоож, түүнийг гэрээний үндсэн дээр дагаж мөрдүүлдэг болгоход чиглэнэ. Энгийнээр хэлбэл малчид нэг дор хоригдох биш, харин дөрвөн өөр газар улирлын бэлчээр эзэмшиж, ган, зудын үед нөөц нутаг ашиглах эрхийг нь албан ёсны болгон баталгаажуулж байгаа хэрэг юм.

Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах нь:

- i. Бэлчээр эзэнтэй болж, зохистой ашиглах, хөрөнгө хүч зарж хамгаалах зэргээр өөриймсөг хандах
- ii. Гэрээт бэлчээрийн хил заагийг тогтоосноор малын тоог хязгааргүй өсгөх биш харин харин эдийн засгийн эргэлтэд оруулан борлуулах, ашиг шим, чанарыг эрхэмлэх сэтгэлгээг төлөвшүүлж
- iii. Бэлчээрийн эдэлбэрээс бусад эдэлбэрт шилжихэд малчид, нутгийн захиргаа, мал аж ахуйн салбарын эрх ашгийг зохистой харгалздаг нөхцөлийг бүрдүүлэх юм.

5. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах явцад ямар бэрхшээл гарч байна вэ?

Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах ажлыг Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон алт, малын эрүүл мэнд” төслийн хүрээнд МБАНХолбоо олон аймаг, сумдад нэвтрүүлж эхлээд байна. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах явцад дараах бэрхшээлүүд гарч байна. Үүнд:

- Гэрээт бэлчээрт гаднаас нүүдэллэн орж ирэх
- Гэрээгээр хүлээсэн улирлын нүүдэл хийх хугацааг зөрчиж орж ирэх
- Отор нэрээр удаан хугацаагаар зорчих
- Гэрээнд заагаагүй бэлчээрийн бус зориулалтаар ашиглах (Уул уурхай, зам, шугам сүлжээ, аялал жуулчлал, байр объект барих гм)
- Малын тоог бэлчээрийн даацал нийцүүлэх үүргээ хангалтгүй биелүүлэх


Энэхүү гарын авлагад малын тоог бэлчээрийн даацал нийцүүлэх үүргээ хангалтгүй биелүүлэхээс бусад бэрхшээлийг хэрхэн даван туулах талаарх зөвлөмжийг тусгав.

6. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах явцад гарч байгаа бэрхшээлийг даван туулах нь

6.1. Гэрээт бэлчээрт гаднаас нүүдэллэн орж ирэх

Гэрээт бэлчээрт гаднаас нүүдэллэн орж ирэх бэрхшээл нь 2 үндсэн шалтгаантай. **Нэгд**, анх гэрээ байгуулахдаа гэрээт бэлчээрийг ашиглах эрхтэй малчдыг дутуу хамруулснаас тэдгээр малчид орж ирэх нь түгээмэл байдаг. **Хоёрт**, гэрээ байгуулсан бэлчээрт бусад малчид ямар нэг шалтгаанаар орж ирэх нь олонтой.

Нэгдүгээр шалтгаанаас үүдэлтэй бэрхшээлийг даван туулах арга зам нь гэрээ анх байгуулахдаа тухайн бэлчээрийг аль нэг улиралдаа ашигладаг, аль эсвэл отроор орж ирдэг байсан малчдыг бүрэн хамруулах буюу тэдний саналыг авч зөвшилцөж байж гэрээ байгуулах, нэгэнт гэрээ байгуулсан бол дээрх малчдыг гэрээнд хамруулах, зөвшилцөх ажлыг нөхөж хийх явдал юм. Гэрээ байгуулах бэлчээрийн хил заагийг тогтоохдоо түүнийг ашиглаж байгаа нийт малчид гэрээнд нэгдэж гарын үсэг зурахын ач холбогдлыг **Зураг 2-р** харуулав. Зураг дээр байгаа цэнхэр хил зааг дотор гэрээнд нэгдээгүй малчин өрхийг улаанаар тэмдэглэж оруулав. Ийм гэрээ байгуулсан тохиолдолд дээрх малчид урьд ашиглаж байсны дагуу гэрээт бэлчээрт орж ирж, маргаан үүсгэх нь түгээмэл. Маргаан үүссэн үед тэдэнд бэлчээр ашиглуулахгүй гэж хэлэх үндэслэл ч байхгүй юм. Иймд эхнээсээ гэрээг зөв байгуулах нь чухал. Зураг дээр зөв байгуулсан гэрээний хилийг улаан өнгийн хил заагаар харуулав. Үүнд гэрээ байгуулахаас өмнө тухайн бэлчээрийг ашиглаж байсан бүх малчид гэрээнд нэгдэж гарын үсэг зурсан нь маргаан гарахгүй байх гол нөхцөлийг бүрдүүлсэн байна.



Зураг 2 Бэлчээрийн гэрээг зөв байгуулах нь

Нийт малчид гарын үсэг зурж, гэрээг зөв байгуулсан хэдий ч бусад малчид ямар нэг шалтгаанаар орж ирэн маргаан үүсгэх бэрхшээл байсаар байна. Үүнийг даван туулахын тулд юуны өмнө Газрын эрх зүйн орчноо сайтар мэдэн өөрсдийн эрх хашгаа хамгаалах, хүчин мөхөсдсөн үед орон нутгийн төр захиргааны байгууллагаар хамгаалуулах чадвартай болох нь хамгийн чухал юм.

Бэлчээр ашиглах харилцааг зохицуулж байгаа гол хууль болох Газрын хуулийн талаар малчид юу мэдвэл зохихыг **Хавсралт 1**-д харуулав.

Гэрээт малчид юу хийвэл зохих вэ?

Гэрээ байгуулсан малчид нь дараах алхмуудыг дэс дараалалтай хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүнд:

1. Юуны өмнө өөрийн гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийн хил заагийг бусдад тодорхой харуулах тэмдэглэгээ хийх /жигжиг овоо босгох, шон зоох гэх мэт/, гэрээгээр ашиглаж байгаа БАХ-ын нэр, газрын зургийг харуулсан самбарыг гаднаас дураар нүүж ирэх эгзэгтэй цэгүүд дээр босгох нь нүүн ирэгсдээс хамгаалж, сэрэмжлүүлэх эхний чухал алхам юм. Энэ ажлыг гэрээ байгуулмагц сумын газрын даамалтай хамтран хийж гүйцэтгэхийг зөвлөж байна.
2. Гэрээ байгуулсан бэлчээрийн хил, заагийн талаарх мэдээллийг багийн хурал, өдөрлөг, сумаас зохион байгуулах бусад нийтлэг арга хэмжээн дээр сурталчилж, бусад малчдад хүргэх нь дураар нүүн ирэгсдээс сэрэмжлүүлэх дараагийн алхам мөн. Энэ ажлыг БАХ, СБАХ, багийн Засаг дарга, сумын холбогдох ажилтнуудтай хамтран зохион байгуулах шаардлагатай бөгөөд баг, сум, СБАХ-ын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгуулж хэрэгжүүлбэл бүр баталгаатай болно.
3. Дураар нүүж орж ирсэн малчидтай уулзаж, өөрийн байгуулсан гэрээний хувийг үзүүлэн тухайн бэлчээрийг гэрээний дагуу хариуцлагатайгаар ашиглаж байгаагаар тайлбарлана. Гэрээний дагуу бэлчээр ашиглана гэдэг нь нийтээр дундаа ашиглахаас өөр журмаар хуулийн дагуу зохицуулагддаг болохыг тайлбарлана. Ингэхдээ Газрын хуулийн 35.3.1-д заасны дагуу бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх үүрэг хүлээсэн, мөн хуулийн 50.1.1-д заасны дагуу бэлчээрийн газрыг зохистой ашиглах хамгаалах үүрэг хүлээснээ тайлбарлаж, дураар нүүж ирэгсэд нь эдгээр үүргийг биелүүлэхэд хүндрэл учруулж буйг тайлбарлаж ойлгуулна. Мөн үнэхээр байгалийн бэрхшээл, ган, зуд болоод нүүж ирэх шаардлага гарсан бол сумын захиргаа, гэрээт малчдаас зохих журмын дагуу урьдчилан зөвшөөрөл авч байж ирэх нүүж ирэх шаардлагатайг анхааруулна.
4. Нүүж ирсэн малчид нь Газрын хуулийн 35.3.5-д заасны дагуу “Гэрээгээр эзэмшиж, ашиглаж буй бусдын газрын хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх үүрэгтэй, мөн бусдын ашиглаж буй газарт хохирол учруулбал зохих журмын дагуу хохирлыг нөхөн барагдуулах үүрэгтэй болохыг тайлбарлаж, хохирол учраагүй дээр гарч явах нь зүйтэй болохыг зөвлөнө.
5. Нүүж ирэгсэд нь дээрх дээрх хууль ёсны шаардлагыг ойлгон хүлээж авбал нүүж гарах хугацааг товлож тохирох бөгөөд эргэж хянаана.
6. Хэрвээ товлосон хугацаанд нүүж гараагүй, аль эсвэл 2-д заасан шаардлагыг хүлээж аваагүй тохиолдолд орон нутгийн төр, захиргааны байгууллагад хандах, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай, энэ нь нүүж ирэгсдэд хүндрэлтэй болох тухай тайлбарлаж ойлгуулна
7. 1-4 заасан алхам үр дүн гарахгүй бол дараагийн шатны арга хэмжээнд шилжинэ.

Газрын маргааны асуудлаар баг, сумын Засаг даргад хандах

Газрын хуулийн 22.2.1-д заасны дагуу багийн Засаг дарга нь “Газрын тухай хууль тогтоомж, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаарх нийтлэг шаардлагын биелэлтийг хангуулах” үүрэгтэй байдаг.

1. Иймд төрийн захиргааны анхан шатны нэгж болсон багийн Засаг даргад асуудлыг тавьж, шийдвэрлүүлэх хүсэлтээ гаргана.
2. Багийн Засаг дарга дураар нүүж ирэгсэдтэй уулзан бэлчээрийг гэрээгээр ашиглагчдын шаардлагыг яаралтай биелүүлэхийг шаардаж, хугацаатай үүрэг өгнө. Ингэхдээ гэрээгээр бэлчээр ашиглаж байгаа малчдын хууль ёсны эрх, үүргийг дахин тайлбарлаж, хуулийн дагуу хариуцлага хүлээх болохыг анхааруулна.
3. Багийн Засаг дарга шаардлагын биелэлтийг өөрийн биеэр аль эсвэл гэрээт малчдаар дамжуулан эргэж хянана.
4. Багийн Засаг даргын шаардлага биелээгүй тохиолдолд гэрээт малчид аль эсвэл багийн Засаг дарга дараагийн шатны буюу сумын Засаг даргад хандана. Сумын Засаг дарга нь тухайн орон нутагт төрийг төлөөлж, бэлчээрийн зохистой ашиглалт, хууль, шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх бүрэн эрх мэдэлтэй субъект юм. Хамгийн гол нь бэлчээрийг ашиглагч малчидтай байгуулсан гэрээнд төрийг төлөөлөн гарын үсэг зурсан тул тэрхүү гэрээний хэрэгжилтийг хангуулах гол хариуцлага хүлээж байгаа төрийн албан тушаалтны хувьд асуудлыг бүрэн шийдэх боломжтой юм.
5. Сумын Засаг дарга нь Газрын хуулийн 20.2.2-д “Газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах” үүрэгтэй гэж заасны дагуу дураар нүүн ирэгсдэд өөрийн биеэр уулзах буюу албан бичгээр хугацаатай үүрэг өгнө. Албан бичигт шаардлага биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тодорхой заана.

Сумын Засаг даргыг алгасан БИНХ сумын ИНХ хүртэл асуудал шийдэгдэхгүй байх магадлал бага юм. Гэвч баг, сумын Засаг даргын идэвх, санаачилга дутсанаас асуудал шийдэгдэхгүй удах эрсдэл бий. Энэ тохиолдолд малчид баг, сумын иргэдийн хуралд хандах шаардлагатай.

Багийн ИНХ, сумын ИТХ-ын оролцоо

Багийн ИНХ нь Газрын хуулийн 22.1.1-д заасны дагуу “Нийтийн эдэлбэрийн газрын ашиглалтыг зохион байгуулах, 22.1.3-д заасны дагуу “Газар ашиглалт, хамгаалалтын талаарх Засаг даргын тайланг хэлэлцэх, дүгнэх” бүрэн эрхтэй юм. Иймд багийн Засаг даргын идэвч санаачилгагүйн улмаас асуудал шийдэгдэхгүй байгаа бол багийн ИНХ-д хандаж Засаг даргын асуудлыг хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах хэрэгтэй юм.

Дээрхтэй адилаар сумын ИТХ нь Газрын хуулийн 20.1.1-д заасны дагуу “Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх бүрэн эрхтэй тул сумын Засаг даргын

идэвч санаачилгагүйн улмаас асуудал шийдэгдэхгүй байгаа бол сумын ИНХ-д хандаж Засаг даргын асуудлыг хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах хэрэгтэй юм.

Сумын бэлчээр ашиглагчдын холбоо /СБАХ/-ын оролцоо

СБАХ нь гишүүдийнхээ эрх ашгийг түүний дотор бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан малчдын эрх ашгийг хамгаалах, энэ талаар төрийн захиргааны байгууллага, бусад малчидтай хэлэлцэж, зөвшилцөн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан төрийн бус байгууллага юм. Иймд СБАХ нь асуудлыг шийдвэрлэхэд малчдыг төлөөлөх, тэдний эрх ашгийг хамгаалах өргөн боломжтой тул дараах байдлаар оролцохыг зөвлөж байна.

1. Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан гишүүн малчдын дунд бэлчээрийн маргаантай холбоотой санал хүсэлтийг улиралд 1-с доошгүй удаа авч байх
2. Гишүүн малчдаас гарсан санал хүсэлтийг барагдуулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, түүнд БАХ нэг бүрээр гарсан санал хүсэлтийг шийдвэрлэх үйл явц ямар шатанд байгаа, цаашид барагдуулах талаар юу хийвэл зохихыг тусгах
3. 2-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үүнд маргалдагч талуудтай газар дээр нь уулзаж, зөвшилцөх, баг, сумын Засаг дарга, баг, сумын иргэдийн хуралтай асуудлыг шуурхай шийдвэрлэх талаар зөвшилцөж ярилцах, шахалт үзүүлэх, баг, сумны иргэдийн төлөөлөгчдийн хуралд оролцож, гишүүдийн эрх ашгийг хамгаалах

Сумын холбогдох албан тушаалтнуудын оролцоо

Дээр дурдсанчлан газрын асуудлыг шийдэх бүрэн эрх мэдэл төрийг төлөөлсөн сумын Засаг даргад байдаг боловч түүний тамгын газрын холбогдох ажилтнууд болох газрын даамал, мал эмнэлэг үржлийн тасгийн бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтэн ихээхэн үүрэгтэй тул тэдний боломжийг ашиглах хэрэгтэй юм.

Газрын даамал нь Газрын хуульд заасны дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох /23.4.2/, газрын хэмжээ заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, координатжуулах, тэдгээрийн кадастрын зургийг үйлдэж, газрын улсын бүртгэлд бүртгэх /23.4.2/, газрын мэдээллийн санг эрхлэх /23.4.4/ үүрэгтэй тул гэрээ байгуулсан малчдынхаа эрх ашгийг хамгаалах ёстой албан тушаалтан юм. Одоогийн мал эмнэлэг, үржлийн тасаг, шинээр байгуулагдах хөдөө аж ахуйн тасгийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн нь сумын хэмжээнд бэлчээрийн зохистой ашиглалтыг хангуулах чиг үүрэг хүлээдэг тул гэрээт бэлчээрт зөвшөөрөлгүй дураар нүүдэллэн орж ирэх зэрэг сөрөг үзэгдэлтэй тэмцэх албан тушаалтан юм. Иймд асуудал гармагц эдгээр хоёр албани тушаалтантай уулзаж, байдлыг танилцуулан маргааныг шийдвэрлэх талаар тэдний дэмжлэгийг авах нь зүйтэй.

6.2 Гэрээгээр хүлээсэн улирлын нүүдэл хийх хугацааг зөрчих

Энэ асуудал нь гэрээ байгуулсан малчдын дунд гарч байгаа. Харин гэрээнээс гадуурх малчид ийм зөрчил гаргавал 6.1-н хүрээнд багтах асуудал түүгээр зохицуулна.

Улирлын нүүдэл хийх хугацааг барих нь бэлчээрийг зохистой ашиглах хамтын шийдвэр байдаг тул түүнийг хэрэгжүүлэх талаар дараах механизмуудыг бүрэн ашиглахыг зөвлөж байна. Үүнд:

1. Улирлын үүдэл хийх /нүүх болон буцаж ирэх аль аль хугацаа орно/ хугацааг товлон хуралд бүх гишүүн өрхийн гол шийдвэр гаргагч /өрхийн тэргүүн/-ийг заавал байлцуулж, шийдвэр дээр гарын үсэг зуруулах нь дараа зөрчил гарахаас сэргийлэх анхны алхам мөн.
2. Дээрх хурал дээр нүүх хугацааг товлосон үндэслэл, нүүснээр гишүүн малчин бүр ямар ашиг хүртэх /бэлчээр сэргэж, нийт гишүүд ашиг хүртэх/, түүнийг зөрчвөл ямар хор хохирол учрах талаар тодорхой хэлэлцэж, гишүүн нэг бүрд сайтар ойлгуулах нь чухал.
3. Нүүх хугацааг зөрчсөн гишүүн малчинд ямар хариуцлага хүлээлгэх талаар мөн тохирч хурлын шийдвэрт тусган гарын үсэг зуруулах нь нөлөөллийн хүчтэй хэрэгсэл болно. Үүнд хурлаар хэлэлцэн нийт гишүүдийн зүгээс шахалт үзүүлэх, гишүүнээс хасахыг сануулах, хугацаа зөрчсөн хоног дутмаар бодож бод, богоор торгож, төлбөрийг дундын санд төвлөрүүлэх гэх мэтийн ойлгомжтой бөгөөд нөлөөлөх чадвартай аргуудыг ашиглана.
4. Нүүсэн хойгуур зөвшөөрөлгүй орж ирэгсдээс сэргийлэх, хугацааны зөрчилд хяналт тавих үүднээс боломжтой бол бэлчээрт нэг өрхийг харуулаар үлдээх боломжгүй бол тодорхой хугацаанд /2 долоо хоногт буюу сард нэг удаа/ эргэж тойрох хуваарь гаргаж мөрдүүлэх, аль эсвэл үүнд хөрш зэргэлдээ малчдыг ашиглах нь нь зөрчил гарахаас сэргийлэх, зөрчлийг эрт илрүүлж, засах боломжийг олгоно.
5. Нэгэнт зөрчил гарсан тохиолдолд түүнийг эхлэн илрүүлсэн гишүүн малчин зөрчил гаргасан этгээдэд хурлын шийдвэрийг сануулан зөрчлийг нэн даруй ариглахыг шаардана.
6. Асуудал шийдэгдэхгүй бол БАХ-ын ахлагч, багийн Засаг дарга, сумын албан тушаалтнуудад шат дараатай хандана.
7. Зөрчил гаргасан этгээдэд урьд тохирсон хариуцлагыг /3-д заасан/ заавал хүлээлгэж байх нь гараа зөрчил гарахаас сэргийлэх гол араг зам болно.

6.3 Отор нэрээр удаан хугацаагаар зорчих

Отор нэрээр болон улирлын бэлчээрт хүрэх үүднээс бусдын гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг дайран өнгөрөх асуудал үүнд багтана. Манай малчид гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран бусдын ашигладаг бэлчээрийг дайран өнгөрөхдөө жудаг барьж, их идүүлж хохирол учруулахгүй байх, хог хаягдлаа үлдээлгүй цэвэрлэдэг гэх мэтийн сайхан заншилтай ард түмэн юм. Гэвч тодорхой шалтгаанаас эдгээр заншил алдагдах нь их болж байна.

Энэ асуудлыг Газрын хуулийн 48-р зүйлээр зохицуулсан байна. Үүнд:

48.1.Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэвтрэх, дайран өнгөрөхийг хориглосон дохио тэмдэг тавих, хашаа барих зэргээр тусгайлан хамгаалаагүй бол хэн боловч тухайн газарт хохирол учруулахгүйгээр нэвтэрч, дайран өнгөрч болно.

48.3.Газар эзэмшигч, ашиглагч болон уг газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглахаар шаардаж буй этгээдийн хооронд хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах эрх үүснэ.

48.4.Газар эзэмшигч, ашиглагч нь газраа бусдад хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглуулснаас уг газрыг зориулалтын дагуу ашиглах боломжгүй болбол тийнхүү ашиглахыг зогсоохыг газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглаж байгаа этгээдээс шаардах эрхтэй гэжээ.

Байнга нүүдэллэж байдаг бэлчээрийн МАА-н хувьд гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт орохыг хориглосон тэмдэг тавих боломжгүй юм. Иймд гэрээт бэлчээр дээгүүр дайран өнгөрч болно гэсэн үг. Харин ингэж дайран өнгөрөхдөө бэлчээрт хохирол учруулахгүй байх үүргийг малчид хүлээж байгааг хуулийн 48.1-д тодорхой заажээ.

Бэлчээрт хохирол учруулахгүйгээр дайран өнгөрөх гэдэг нь ерөнхий заалт тул үүнийг журмаар зохицуулахыг зөвлөж байна. Журмыг сумын ИТХ-ын тогтоолоор батлан хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Журмын төслийг доор харуулав.

Бэлчээрийн газрыг мал дайран өнгөрөх журам /төсөл/

Бэлчээрийг гэрээгээр ашиглуулсан нөхцөлд бэлчээрээ гэрээгээр ашиглаж байгаа малчдын эрх ашгийг хамгаалах зайлшгүй шаардлага тулгардаг. Нэн ялангуяа гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дээр бусдын мал дураараа бэлчээрлэх, дайран өнгөрөх нэрээр идүүлэн талхлах зэрэг сөрөг үйлдлийг хязгаарлах хэрэгтэй. Энэ зорилгын үүднээс сумын захиргааны зүгээс бэлчээрийн газрыг мал дайран өнгөрөх журмыг батлан мөрдүүлэх нь зүйтэй юм.

Энэхүү журмын гол зорилго нь малчид жилийн дөрвөн улиралд нутаг сэлгэх, отрын нөөц бэлчээр уруу орох, ган, зудтай үед бусад баг сум, аймгийн нутаг уруу нүүдэллэн орох үедээ замын бэлчээрийг мал сүрэг дайран өнгөрөх асуудлыг зохицуулахад оршино.

1.Ерөнхий зүйл

1.1 Малчдын эзэмшил ашиглалтад байгаа бэлчээрийн газарт нэвтрэх дайран өнгөрөхийг хориглосон тэмдэг тавьсан буюу тусгайлан хамгаалаагүй бол тухайн нутаг бэлчээрт нэвтрэн орж, бэлчээрт байгаа хадлангийн талбай, хашаа хороо, худаг ус, гол ус, рашаан булаг, мод жимс болон бусад байгалийн баялагт хохирол учруулахгүйгээр дайран өнгөрч болно.

2.Сумын ИТХ болон Засаг даргын эрх, үүрэг

2.1 Малчид болон мал бүхий иргэд бусдын гэрээгээр ашиглаж байгаа нутагт нэвтрэх, дайран өнгөрөх үедээ бэлчээрт малаа байлгах хугацааг дайран өнгөрөх тусгай маршрутын замыг бусад малчдын малын бэлчээрт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байхаар тухайн жилийн бэлчээрийн ургамлын ургац, малын тарга хүч нүүх чиглэлээс хамааран жил бүр өөрчлөн тогтоох саналыг тухайн сумын газрын даамал, МЭҮТ, байгаль орчны байцаагч, багийн Засаг дарга нар хамтран боловсруулан сумын ИТХ-д оруулан шийдвэрлүүлнэ.

2.2 Сумын ИТХ-ын шийдвэрийг малчид жилийн 4 улиралд нутаг сэлгэх, отрын нөөц нутаг бэлчээр уруу орохдоо хэрхэн биелүүлж байгааг сумын МЭҮТ, газрын даамал, байгаль орчны байцаагч, багийн засаг дарга нар хянаж хэрэгжүүлнэ.

2.3 Малчид бусдын бэлчээрийг дайран өнгөрөхдөө гаргасан элдэв зөрчлийг сум, багийн засаг дарга нар цаг тухайд нь эцсийн шийдвэр гаргаж зохицуулна.

4. Бусдын ашиглаж буй бэлчээр нутгаар дайран өнгөрөх малчдын эрх, үүрэг

3.1. Бэлчээрийг улирлаар сэлгэх болон отор нүүдэл хийх зорилгоор бусдын ашигладаг бэлчээрийг дайрч өнгөрөхдөө бусад малчдын өвөлжөө, хаваржаа, худаг уст цэгүүдийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх.

3.2. Сум багаас тусгайлан зааж өгсөн маршрутын дагуу тогтоосон хугацаанд нь малыг бэлчээж сум, багын зүгээс тавьсан шаардлага зөвлөмжийг биелүүлэх

3.3 Нүүдэллэж яваа малчдад онцгой тохиолдол гарч замдаа буудаллах хугацааг уртасгах шаардлага гарвал багийн засаг дарга бэлчээрээ ашиглуулж байгаа малчдад заавал мэдэгдэж зөвшилцөлд хүрнэ.

3.4. Бэлчээрийг дайрч өнгөрөх малын тоо толгой төрлийг баг суманд үнэн зөв мэдээлэх ба тохиролцсон малын төрөл тоо толгойг барих

3.5. Халдварт өвчин бүхий малыг бусдын бэлчээр нутгаар дайран өнгөрүүлэхгүй байх. Өвчин гарсан тохиолдолд сум багын зүгээс тусламж авах

3.6 Нүүдэллэж яваа малчдад онцгой тохиолдол гарч замдаа буудаллах хугацааг уртасгах шаардлага гарвал багийн засаг дарга бэлчээрээ ашиглуулж байгаа малчдад заавал мэдэгдэж зөвшилцөлд хүрнэ.

3.7 Өөр сумын нутагт цаг агаарын хүндрэлтэй үед отор нүүдэл хийж яваа малчид тухайн сумын засаг даргатай байгуулсан гэрээний заалтыг чанд биелүүлэх үүрэгтэй.

4. Бусад малчдыг өөрийнхөө бэлчээрээр дайран өнгөрүүлэгч малчдын эрх, үүрэг

4.1. Бусад малчид тэдний гэрээлэн ашиглаж байгаа бэлчээрээр дайран өнгөрөхдөө сумын ИТХ-аас гаргасан шийдвэрийг бүрэн биелүүлж байгаад хяналт тавина.

4.2. Тэдний гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт буудаллах хугацааг хэтрүүлэх, халдварт паразит өвчтэй малыг оруулах, тухайн орон нутагт байгаа өвөлжөө, хаваржааны хашаа, худаг ус, байгалийн нөөцөд онцгой хохирол учруулсан тохиолдолд шаардлага тавих, холбогдох сум, багийн Засаг даргад мэдэгдэж, арга хэмжээ авхуулна.

4.3. Онцгой тохиолдол гарсан үед бэлчээрээр дайран өнгөрөгч малчдад бэлчээрээ ашиглуулах хугацааг сунгаж байлгах тохиролцоонд хүрч болно.

6.4 Гэрээнд заагаагүй бэлчээрийн бус зориулалтаар ашиглах (Уул уурхай, зам, шугам сүлжээ, аялал жуулчлал, байр объект барих гм)

Газрын хуулийн 35.1.1-д газар ашиглагч нь тухайн газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах ёстойг тодорхой заасан байдаг. Харин энэ үүргээ үл хайхарч, газрыг

зориулалтын бусаар ашигласан бол байгуулсан гэрээг хүчингүй болгож, газар ашиглах эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг Газрын хуулийн 40.1.1-д тодорхой заасан байна.

Бэлчээр ашиглах гэрээ нь газрыг гагцхүү бэлчээрийн МАА эрхлэх буюу мал идээшлүүлэх зориулалтаар ашиглах эрхийг малчдад өгдөг бөгөөд бусад зориулалтаар ашиглах нь хуулиар хориотой байдаг юм. Харин өөрийн зөвшөөрөлтэй бууц дээр гэр, байшин, хашаа барих эрх нээлттэй байгаа. Түүнчлэн байгаль орчин сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр бэлчээрийн газар дээр байгаа ховор, нэн ховордсоноос бусад ургамал түүх, түгээмэл тархацтай элс, хайрга, чулуу зэрэг ашигт малтмал ашиглах эрх нээлттэй байдаг. Тухайлбал, иргэн ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр ашиглаж болно /Байгалийн ургамлын тухай хуулийн 12-р заалт/. Харин элбэг ургамлыг иргэн хүнсний, техникийн болон ургамлын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах зориулалтаар ашиглаж болох юм /Байгалийн ургамлын тухай хуулийн 13.1 дэх заалт/. Харин элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах бол заавал эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авдаг хуультай.

Амьтны тухай хуулийн дагуу ан хийх зөвшөөрөл авсан иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болох юм /28.1 дэх заалт/.

Дээрхээс бусад тохиолдолд нэн ялангуяа уул уурхайн зориулалтаар ашиглах, дур мэдэн зам гаргах, шугам сүлжээ байгуулах, зөвшөөрөлтэй бууцнаас өөр газар барилга, объект дур мэдэн барих, аялал жуулчлалын цэг байгуулах нь хориотой юм. Эдгээр заалтыг зөрчвөл Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх тухай Газрын хуулийн 63-р зүйлд тодорхой заасан байна. Иймд эдгээр хуулийн заалтыг зөрчихгүй байх нь иргэн малчин бүрийн үүрэг төдийгүй нийт БАХ-ын нэр хүнд, цаашлаад бэлчээр ашиглах гэрээний эрхэд сөргөөр нөлөөлж болзошгүйг анхаарч, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахыг зөвлөж байна.